

**Ю.Н.РЕРИХ "ДЭВТЭР ОНБО" ХЭМЭЭХ ТӨВД СУРВАЛЖ БИЧГИЙГ
ОРЧУУЛСАН ТУРШЛАГААС¹**

Д. Бүрнээ *

Шоннубалын "Дэвтэр онбо" зохиолыг судалсан, ашигласан тухай

Төвдийн түүх бичлэгийн нэртэй зохиол бол "Дэвтэр онбо" хэмээх зохиол гэж үздэг. Тус зохиолыг төвдийн нэрт түүхч Гой лозава Шоннубал (1392-1481) бичжээ. Тавдугаар Далай лам болон бусад зохиогчид түүнийг "түүхчдийн дунд ижилгүй" эрдэмтэн хэмээн тооцдог бөгөөд энэ зохиолыг 1476 онд эхэлж, 1478 онд дуусгасан байна. "Дэвтэр онбо"-ын зарим мэдээг сүүлийн үеийн түүхчид маргаантай гэж үздэг ч энэ ном төвдийн түүхийн зохиолын дотор өнөө хүртэл хамгийн баялаг мэдээ баримтыг агуулсан зохиол гэж нэр алдар нь дуурсаар ирсэн билээ.

Монголын дундад зууны түүхчид эл зохиолоос эшилсэн байдаг. Тухайлбал Мэргэн гэгээн "Алтан товч" хэмээх сурвалж бичгийг бичихдээ Энэтхэгийн хаадын залгамжийг ашигласан байдаг². Европын эрдэмтэн А.Чома де Кереш, В.П.Васильев, С.Ч.Дас, Б.Барадин нар тус зохиолыг дурдсан байна. Ч.Белл "Дэвтэр онбо" зохиолын товч гарчгийг дурдаж, Ж.Туччи тус зохиолоос хэсэглэн авч хэвлүүлжээ³.

"Дэвтэр онбо" зохиолыг гурван удаа бард бүтээжээ. Анхны хэвлэлийг Янбажан хийдэд, хоёр дахи хэвлэлийг Лхасын Гүндэлин хийдэд барласан нь 485 хуудас болно. Гуравдахи хэвлэлийг Амдогийн Амчоггонба хийдэд хоёр боть болгон барлажээ. Эхний боть ерийн хэмжээний цаасаар 297 хуудас, хоёрдахи боть 271 хуудас болно. "Дэвтэр онбо" агуулгын хувьд юуны өмнө төвдийн бурханы шашны түүхийн зохиол болно. Үүний зэрэгцээ Төвдийн иргэний түүхээс багагүй мэдээ баримтыг дурджээ. Тус зохиолын эхний номд бурхан Буддагийн ургийн түүх болон намтар, Энэтхэгийн бурханы шашны түүхийн холбоотой товч мэдээ, төвдийн хаадын ургийн түүх, төвдийн бурханы шашны эхэн үеийн дэлгэрлийн тухай товч мэдээ, төвдийн хаадын талаарх эш бошго, монгол хаадын ургийн түүхийг өгүүлжээ. Хоёрдахи ном төвдийн шашны хожуу дэлгэрлийн тухай, төвдийн буддын шашны янз бүрийн урсгал чиглэл, тусгай нууц номлол, тахил шүтээн зэргийн тухай өгүүлсэн 15 бөлгөөс бүрдэнэ.

¹) Ю.Н.Рерихийн мэндэлсний 110 жилийн ойд тавьсан илтгэл.

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Эх бичиг судлалын тэнхим

²) Мэргэн гэгээний Алтан товч, монгол бичгээс крилл бичигт хөрвүүлэн, оршил, тайлбар бичсэн Д.Бүрнээ, УБ., 2006.

³) А.И.Востриков, Тибетская историческая литература, Москва 1962, стр.93.

Ю.Н.Рерихийн орчуулгын зарим онцлог

Ю.Н.Рерих орчуулгадаа бичсэн дэлгэрэнгүй оршилоос тус орчуулгаа хийхийн тулд ямар их эрэл хайгуул, судалгаа шинжилгээ хийснийг тодорхой харж болно. Тус оршилд "Дэвтэр онбо" хэмээх зохиол төвдийн түүхийн сурвалж бичгийн судлалд ямар байр суурьтай болох тухай өгүүлжээ. Мөн зохиогчийн намтартай холбоотой мэдээ баримтыг дурдаж, тус зохиолыг судалсан байдлыг авч үзэхийн сацуу тус зохиолын агуулга бүтэц, ашигласан гол сурвалж бичгүүд, тэдгээрийн онцлогийг дурджээ. Ю.Н.Рерих "төвдийн түүхэн дэхи үйл явдлын он дарааллыг зөв тогтоох талаар хийсэн Гой лозава Шоннубалын оролдлого нь үнэлж баршгүй" хэмээн дүгнэжээ⁴. Тэр бээр цааш нь Гой лозава Шоннубал асар их хэмжээний мэдээ баримт ашигласан, тэр дундаа сүм хийдийн он дарааллын бичгүүдийг шүүж үзсэнийг онцлон дурдаад, гол ашигласан хэрэглэгдэхүүн нь намтар зохиол, чойнжүн болохыг тэмдэглэхийн сацуу зохиолын хэл найруулгын талаар саналаа бичсэн байна. Тус зохиолыг Гой лозава Шоннубал нас сүүдэр 84 хүрсэн үедээ бичсэн бөгөөд бусад хүмүүст хэлж бичүүлсэн байдалтай зохиолын хэл найруулга жигд биш байгааг Ю.Н.Рерих дурджээ. Тус сурвалж бичгийн ололттой талыг тэр бээр дурдахын сацуу зарим нэгэн алдаа мадаг байгаа талаар бичсэн байна. Үүнд төвд сурвалж бичигт нийтлэг байдаг алдаа "Дэвтэр онбо"-д бас байгааг тэмдэглэжээ. Энэ нь төвдийн Сронзангамбо хааны мэндэлсэн он болон төвд дэхи буддын шашныг Ландарма хаан хавчин сөнөөсөн оны талаарх зөрөөтэй мэдээ бөгөөд 978 оноос (төвдөд буддын шашин дахин сэргэсэн он) 60 жилээр урагшлуулсанаас энэ зөрөө гарсан гээд төвдийн түүх бичлэгт Сронзангамбо хааны мэндэлсэн оныг Гой лозава Шоннубалын тогтоосноор 629 он гэж тэмдэглэж ирсэн уламжлалтай гэжээ. Зохиолоос эшлэхдээ Гой лозава Шоннубал бээр алдаа гаргасныг Ю.Н.Рерих бас дурджээ. Тухайлбал: Будон Ринчендүв Төвдөд буддын шашин Уй, Занд доройтоод, 70 жилийн дараа сэргэсэн гэснийг Гой лозава Шоннубал 73 жил гэж эндүүрсэн болохыг магадлажээ⁵. Эдгээр баримтаас үзвэл Ю.Н.Рерих тус төвд сурвалж бичгийг орчуулахын тулд бусад сурвалж бичгийн мэдээ баримттай нарийн нягталж шинжилсэн болох нь харагдаж байна.

Ю.Н.Рерихийн орчуулсан "Дэвтэр онбо" бол уран зохиол биш түүхэн сурвалж бичиг юм. Уран зохиолын орчуулгад зохиолын утга агуулгыг буулгахаас гадна хамгийн гол нь уран сайхныг буулгах явдал чухал байдаг. Тэгвэл Ю.Н.Рерих энэхүү түүхэн сурвалж бичгийг хөрвүүлэхдээ утгаас гадна хамгийн их анхаарсан зүйл бол эрдэм шинжилгээний чанартай зүүлт тайлбарыг хийсэн явдал юм. Тухайлбал Ю.Н.Рерих тус зохиолд Гой лозава Шоннубалын олонтоо эш татсан номын нэрийг буулгахдаа Ганжуур, Данжуурын ямар аймагт багтах, ямар боть болох төдийгүй тухайн эшлэл хэд дүгээр хуудсанд буйг тэмдэглэсэн нь уг номыг үзэх ашиглах хүмүүст чухал хэрэглэгдэхүүн болж байгаа юм.

Нөгөөтэйгүүр тухайн дурдсан номын талаар гарсан судалгаа шинжилгээ байвал түүнийг бас тодорхой заах төдийгүй тухайн мэдээ баримт бусад ямар төвд сурвалж бичигт буйг хуудас зааж тэмдэглэснээс нь Ю.Н.Рерих төвдийн утга зохиолын талаар ямар их өргөн мэдлэгтэй байсныг харж болно. Тухайлбал Гаутам бурханы талаар өгүүлсэн зүйл дээр холбогдуулж тус бурханы түүхийг "Бадамгатан", "Ладаг жалрав"-т

⁴) The Blue Annals, Parts I & II, George N.Roerich, 1996, pp.iii.

⁵) The Blue Annals, Parts I & II, George N.Roerich, 1996, pp. XIV.

өгүүлсэнээс гадна А.Франке, В.Рокхил нар бүтээлдээ дурдсаныг тодорхой тэмдэглэсэн байгаа юм.

Ер нь Ю.Н.Перих сурвалж судлаач эрдэмтний хувьд "Дэвтэр онбо" зохиолд дурдсан аливаа мэдээ баримтыг зүгээр орчуулаад өнгөрсөнгүй, зайлшгүй бусад түүхэн сурвалж бичгийн мэдээ баримттай харьцуулан тодолсон байна. Тухайлбал тус зохиолд олонтоо эш татсан Ганжуур, Данжуур дахи номын нэрсийг Будон Ринчендүвийн бүртгэлтэй зэрэгцүүлэн үзэхийн сацуу Нартан, Дэргэ барын Ганжуур, Данжуур дахи ном судартай тулгаж тодруулсан байна. Гой лозава Шоннубал номын нэрийг төвдийн түүх бичлэгийн уламжлал ёсоор хураангуй товч нэрээр дурдсан байх тул тэдгээрийг тодлох нь амар хялбар биш. Нэгэн жишээ дурдъя. Энэтхэг гаралтай номын нэрийг орчуулахдаа ямагт санскритаар нь сэргээж бичээд хаалтан дотор төвд нэрийг тавьжээ. Жишээ нь: "Дүй жай дан дүй ма жай намбар эй вий сүм жү за сүм ба" ('dus byas dang 'dus ma byas nam paṅ nges pa'i le'u sum bcu rtsa gsum pa las)⁶ гэсэн номын нэрийг санскритаар Saṃskṛtāsaṃskṛtaviniścaṣa-nāma гэж бичээд Нартан барын Данжуурын 128 дугаар ботийн 252a-252б- талд буйг зааж тэмдэглэсэн байх жишээтэй. Энэтхэг гаралтай газар орны нэр, хүний нэрийг "Дэвтэр онбо"-д төвд хэлээр орчуулсан байдаг тул тэдгээр нэрийг мөн санскритаар нь сэргээж бичсэн байна. Тухайлбал: "Сэржа" (ser skya)⁷ хэмээх балгасын нэрийг Капилавасту гэж бичих жишээтэй. Зарим газрын нэрийг хаана оршдог болохыг ч тодолжээ. Жишээ нь: "Lha sa'i jo bo skyo rond du bskyal" гэсэн өгүүлбэрийг *carried the image of Buddha of Lha sa away to sKyī rong* (on the border of Nepal) (Бурханы хөргийг Жиронд хүргэв)⁸ буюу Жирон хэмээх газрыг Балбатай хил залгаа орон газар гэж тэмдэглэсэн байна. Хүний нэрийг орчуулсан тухайд "жалбо манбогүрви" (rgyal po mang po bkur)⁹ гэснийг *Махасаммата*, Санмо (bzang mo) гэсэн нэрийг *Bhadri* гэж санскритаар бичжээ. Төвд оноосон нэрийг латин галигаар тэмдэглэсэн учраас судлаачид төөрч будилахгүй зөв бичлэгийг шууд олж авах боломжтой. Ю.Н.Перихийн төвд үсгийн галигийн тухайд нэрийн шүтээн үсгийг томоор тэмдэглэдэг, зарим нэмэлт тэмдэг бүхий үсгээр галигласан байна.

Монгол хүний нэрийг хөрвүүлсэн тухайд авч үзье. Монгол хаадын нэрийн хөрвүүлэхдээ өөрийн хөрвүүлгийн хажууд Саган сэцэний бичлэгийг зэрэгцүүлж тавьсан байх тул харьцуулж үзэх боломжийг өгч байгаагаараа ач холбогдолтой. Гой лозава Шоннубал монгол хаадын залгамжийн талаар бичихдээ Гунгаадоржийн "Дэвтэр марбо" хэмээх зохиолыг ашигласан болохыг Ю.Н.Перих тэмдэглэжээ. Ер нь Гой лозава Шоннубал зарим хүний нэрийг эндүү ташаа буулгасныг Ю.Н.Перих залруулсан байна. Тухайлбал Хайдугийн хөвгүүн Байшинхорын нэрийг Байшин, Хордогшин гэж хоёр нэр болгосныг залруулжээ¹⁰. Монгол хүний оноосон нэрийг Ю.Н.Перих орчин цагийн дуудлагад ойртуулж буулгасан байна. Тухайлбал "Bar than ba dur" хэмээх нэрийг *Bartan ba'atur* гэж буулгажээ¹¹. Өгөдэйн хүү Го-лүг гэж Гой лозава Шоннубалын бичсэнийг Гүег хааны нэрийн ташаарсан бичлэг бололтой гээд түүнийг тус сурвалжид 6 сар хаан ширээнд суусан гэснийг залруулж 2 жил буюу 1246 оны 8 сараас 1248 оны 4 сарын

⁶⁾ The Blue Annals, Parts I & II, George N.Roerich, 1996, pp. 21.

⁷⁾ The Blue Annals, Parts I & II, George N.Roerich, 1996, pp. 3.

⁸⁾ The Blue Annals, Parts I & II, George N.Roerich, 1996, pp. 21.

⁹⁾ The Blue Annals, Parts I & II, George N.Roerich, 1996, pp.3.

¹⁰⁾ The Blue Annals, Parts I & II, George N.Roerich, 1996, pp.57.

¹¹⁾ Мөн тэнд.

хооронд хаан ширээнд суусан гэж тодолжээ¹². Цаашилбал: Чингис хаан 5 дүүтэй байсан гэсэн сурвалжийн мэдээг орчуулахдаа дүү нарынх нь нэрийг тоочжээ.

Монгол хаадын залгамжийн тухай бичихдээ энэ талаар тухайн үед судалсан эрдэмтэдийн судалгааг дурдсан байна. Тухайлбал Э.Хениш, С. Козин, Я.Шмидт, П.Кафаров нарын судалгааг дурджээ. Чингис хааны мэндэлсэн талаар төвд сурвалжид усан морин жил буюу 1162 он гэж тэмдэглэсэн байдаг атал Шоннубал 1182 гэж тэмдэглэсэн нь эндүүрэл бололтой гэжээ.

Нэр томъёог хэрхэн орчуулсан талаар товч авч үзвэл тухайн үгийн гарал үүслийг давхар тэмдэглэжээ. Тухайлбал: “Эд ранги рин ла дэи жаса ёд дам дий вай” (*nged rang gi ring la de'i 'ja sa yod dam dris pas*) гэсэн өгүүлбэрийг *Can I obtain in this lifetime His benediction* буюу “би энэ насандаа түүний \бурханы\ өршөөлийг хүртэх болов уу хэмээн асуусан” гэж Ю.Н.Перих орчуулаад тус өгүүлбэрт орсон “жаса” бол гэсэн *jasak* гэсэн монгол үг болохыг тэмдэглэсэн байна. Ингэхдээ эл үг “өршөөл” гэсэн утгаар оржээ гээд асуултын тэмдэг тавьжээ¹³. Ю.Н.Перих энэ үгийг өөрийн зохиосон толь бичигтээ монгол гаралтай болохыг тэмдэглээд орос хэлээр “указ, эдикт”, англиар *edict* гэжээ. Асуултын тэмдэг тавьсан нь тус үг “цааз”, “засгаас” өөр утгаар орсонг нягтлаж үзэхийг сануулсан хэрэг бололтой. Энэхүү үг үнэхээр монгол гаралтай бөгөөд түүний язгуур болох “заса” гэсэн үг бол засан тохинуулах гэсэн утгатай бөгөөд “Хорин нэгтийн тайлбар толь”-д “Мууг сайн болгон халах, тэнгэрийн доорхи хэргийг шийтгэх, бичгийн үгийг зохистой сайн болгох, төвийг үзэн, тушаа тушаа захиран тэгш нийгэм болгохыг засна” гэж тайлбарлажээ¹⁴. “Мууг сайн болгох” буюу засан сайжруулах гэсэн утгаар орсон учир дээрх өгүүлбэрийг төвд хэлнээс монгол хэлнээ “энэ насанд минь намайг тэтгэх болов уу” гэж орчуулж болмоор санагдаж байна. Ингэж үзвэл Ю.Н.Перихийн дээрх орчуулга эргэлзээгүй дүйсэн орчуулга болох юм. Ю.Н.Перих орчуулгаа энэ мэт маш нягт нямбай хийж байсныг бид ажиглаж болно.

Зарим нэр томъёоны чанартай төвд үг хэллэгийг англи хэлнээ орчуулаад хаалтанд санскрит болон төвд бичлэгийг галиглажээ. Тухайлбал “сэмжан” (*sems can*) гэсэн үгийг *animated beings* гэж орчуулаад санскрит, төвд галигийг бичжээ. Монголоор “бинвад идээ”, төвдөөр “соднём” (*bsod nyoms*) гэж орчуулах үгийг *saints food* (гэгээнтний хүнс) гэж орчуулжээ. “Бинвад” гэдэг үг бол монгол хэлнээ санскрит хэлнээс уйгар хэлээр дамжиж орсон үг. Энэ үгийг Ю.Н.Перих толь бичигтээ *alms giving to the buddhist monks* (буддын шашинтанд өгөх өглөг) гэж тайлбарлажээ. Харин санскрит гаралтай нэр томъёог латин үсгээр галиглаж бичсэн байна. Тухайлбал “ня-ан-лай дай” (*nga ngan las 'das*) буюу монгол хэлнээ орчуулбал “гаслангаас нөгчих” гэсэн үгийг “нирвана” (*nirvana*) гэж санскритаар нь буулгажээ. “Зүглагхан” (*gtsug lag khang*) буюу сүм хийд гэсэн үгийг *vihara* гэж санскритаар, харин “шашин” (*bstan pa*) гэсэн үгийг *Religion* (шашин) гэхгүй *Doctrine* (сургаал номлол) гэж англи хэлээр орчуулсан нь төвд хэлээр “шашин” гэсэн үгийг бас “чой” (*chos*) буюу ном сургаал, шашин гэж орчуулах ёс байдгийг бодолцсон хэрэг юм.

Дүгнэж хэлбэл Ю.Н.Перих бол нэртэй монголч, төвдөч эрдэмтэн төдийгүй нэртэй орчуулагч байжээ. Тэр бээр маш нягт нямбай, ажигч гярхай, эрдэм шинжилгээний

¹²⁾ The Blue Annals, Parts I & II, George N.Roerich, 1996, pp.58.

¹³⁾ ja-sa<jasa used here in the sense of benediction?

¹⁴⁾ Ш.Чоймаа, “Их засаг”-ийн нэрийн тухайд, Монгол судлалын өгүүлүүд, Улаанбаатар, 2003, 284-р тал.

ажилд чин үнэн сэтгэлээсээ ханддаг, дорно дахины судлал тэр дундаа буддын судлал монгол төвд судлалын талаар гүн гүнзгий, олон талын мэдлэгтэй, маш их ажилч хичээнгүй, туйлын их хөдөлмөрч байсныг түүний орчуулгаас харж болох байна. Энэ орчуулга нь төвд, монгол сурвалж бичиг судлаачдад сурвалж бичгийг судлах, орчуулахад үнэлж баршгүй чухал хэрэглэгдэхүүн, гарын авлага болох бүтээл юм.

Ю.Н.Рерихийн "Дэвтэр онбо" хэмээх сурвалж бичгийн орчуулга "Blue Annals" нэртэйгээр 1949 онд анх хэвлэгдсэн бөгөөд хожим 1976, 1978, 1988, 1995, 1996 онуудад тус тус хэвлэгдсэн байна. Ю.Н.Рерихийн англи орчуулгыг орос хэлнээ 2001 онд дам орчуулан гаргажээ¹⁵.

SUMMARY

"Deb-ther sngon-po" is considered to be one of popular Tibetan historical sources. The book was written by a recognized Tibetan historic Gos lo-tsa-ba gzhon-nu-dpal (1392-1481), translated from Tibetan to English by George. N. Roerich, a renowned Russian scholar of Tibet and Mongolian study, and published for the first time in 1949 with a name, "Blue Annals". Later, it was published again in 1976, 1978, 1988, 1995, and 1996, respectively. George. N. Roerich wrote in his scholarly comprehensive introduction what role the given work has played in Tibetan historical writing and how it studied the history. From George. N. Roerich's translation, it can be clearly seen how much thorough research and effort he put into the work.

¹⁵) Гой-лоцава Шоннупэл, Синяя летопись История буддизма в Тибете, перевод с тибетского Ю.Н.Рериха, перевод с английского О.В.Альбедилля и Е.Ю.Харьковой, Санкт-Петербург, 2001.